

**МОНГОЛЧУУДЫН ГАЗАР УСАНДАА НЭР
ӨГДӨГ УЛАМЖЛАЛ, БЭЛГЭДЛИЙН
УЧРЫГ УХААРАХ**



“МОНГОЛЧУУД АМНЫ БУЗРААС ЦЭРВЭЖ, БЭЛГЭТЭЙ САЙХАН ҮГЭЭР ХЭЛЭЛЦДЭГ



САЙН ЖИШЭЭ

Хилийн цэргийн С.Гүржав гэж генерал бий. Нутгийнхан түүний ийнхүү сайн явааг нь ээжийнх нь амны билэгтэй холбодог. С.Гүржавын ээж хүүгээ хар багаас нь “генерал” хэмээн дууддаг байжээ. Айлд сууж байснаа “За харьж цайгаа чаная даа. Манай генерал хичээлээсээ ирэх цаг болчихож” гээд гараад явчихна.



МУУ ЖИШЭЭ

Нэгэн эх хүүгээ хар багаас нь “Энэ муу шоронгийн хадаас” гэж загнадаг байв. Өөрт нь таалагдахгүй үйлдэл хийх болгонд энэ үгээрээ загнана. Хачин сэргэлэн хүү хожим нь ялих шалихгүй асуудлаар орон шоронгийн хаалга хэдэнтээ татаж, гандуу гундуу явж байгаад хэдхэн жилийн өмнө хүний хорвоог орхисон доо.

ГАЗАР УСАНДАА ӨГДӨГ НЭРИЙН БЭЛГЭДЭЛ

Өлзий бусын нэрийг сольсон нь

1900-аад оны эхээр алдартай шинжээч Амарбуянтын хийдэд заларч иржээ. Энэ үед хошуу ихэд ядуурсан байсан тул хошууны эрхтнүүд энэ байдлаас яаж гарах тухайгаа тэр хүнээс асуужээ. Шинжээч хошууны газрыг шинжээд: “Хойт шувуун бааст, Дунд шувуун бааст, Урд шувуун бааст гэдэг газруудын нэр өлзий бус байна. Эдгээрийг Хойт жаргалант, Дунд жаргалант, Урд жаргалант гэж нэрлэсүгэй. ...Жад, Мөст хэмээх нэртэй газраас илд зэвсэг, мөс цасны хорлол гарах учир Цэнгэлтэй хэмээн нэрлэ. Гээмэл нэртэй газрыг Эрдэнэ Тээл болгосугай” хэмээн хэлээд “Одоо танай хошуу гайгүй өөдөлж дэвжинэ” гэсэн нь ёсоор болжээ. Эдгээр газар нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт байдаг¹¹².

Бэлгэдэлт сайн газар усны нэр	Өлзий бусын газар усны нэр
Хойт жаргалант, Цэнгэлтэй, Эрдэнэ Тээл	Хойт шувуун бааст, Жад, Мөст, Гээмэл
Яагаад бэлгэдэлтэй вэ?	Яагаад бэлгэдэлгүй вэ?
Нэр сольсны ач холбогдол юу вэ?	Нэрээс шалтгаалсан хор уршиг юу вэ?

ӨРГӨМЖ НЭРИЙН УЧИР

Гол усны дэргэд оноосон
нэрээр нь дуудахгүй
байх

Усанд бохир зүйл
оруулахгүй байх

Төрөөс болон ард
олноос цол хэргэм
олгох



Багаж хэрэгсэл хэрэглэхгүйгээр баялгаа шинжин мэддэг



01

Амтлах

02

Үнэрлэх

03

Чагнах

04

Харах

БАЯЛАГААР ГАЗАР УСЫГ НЭРЛЭХ

“ЭРДЭНЭТИЙН ОВОО” ХЭМЭЭХИЙН УЧИР

“Эрдэнийн цагаан чулуутай газар байна. Энэ уулын эзэн нь 4 хөл нь тавиу, жороо эрдэнийн ногоон морь байна” хэмээн Амарбаясгалант хийдийн Хайдав лам шинжсэн.



ДАРХАН ЦААЗАТ БОГД ХАН УУЛ

Богд Хан Уул эртнээс бөө мөргөлийн шүтээн, тайлга тахилгын газар байсан бөгөөд 13-р зууны үеэс Хэрэйдийн Ван Хан Туулын Хар шугуйд нутаглаж байхдаа Хан Ууланд ан гөрөө хийх, гал хөс түлэхийг хориглодог байжээ.

Манжийн хаан Тэнгэрийг тэтгэсний 43-р он буюу нийтийн тооллын 1778 онд Их Хүрээний сайд ван Юндэндорж, харьяа түшмэл Санжаадорж нарын айлтгал бичгээр Богд Хан Уулыг зарлигаар тахих болсон. Богд Жавзандамба хутагтын цолыг Хан Ууланд өргөснөөр Богд Хан Уул гэх болсон гэдэг. Энэ уулын хоёр ноён оргилд Цэцээ гүн, Түшээ гүн гэсэн цол олгож, жил бүр улсын сангаас цалин пүнлүү олгодог байсан байна.


Мөн энэ үеэс Богд Хан Ууланд Өмнийг Тэтгэгч Цагаан Лавай Дүнжингарав гэдэг нэрийг өгсөн гэдэг. Богд уулын бараа харагдах газар хүн цаазаар авдаггүй байсан гэдэг. Тэнгэрийг тэтгэгч хааны зарлиг гарсны дараанаас 1779 оны шарагчин гахай жил Халх дөрвөн аймаг, шавь таваараа нийлэн тахиснаас хойш зарлигаар жилд хоёр удаа зун, намарт тахьдаг болсон гэдэг. Хувьсгалын жилүүдэд Хан Уулын тахилга тасалдсан байсан ч 1995 он Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 365 жилийн ойгоор Цэцээ гүний оргилыг тайж, 2004 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн тахилгатай уулсын нэг болгож 5 жилд нэг удаа төрийн тахилга үйлдэх болсон.

1778 онд Их Хүрээний сайд ван Юндэндорж, харьяа түшмэл Санжаадорж нарын айлтгал бичгээр Богд Хан Уулыг зарлигаар тахиx болсон. Богд Жавзандамба хутагтын цолыг Хан Ууланд өргөснөөр Богд Хан Уул гэх болсон гэдэг. Энэ уулын хоёр ноён оргилд Цэцээ гүн, Түшээ гүн гэсэн цол олгожээ.



Тэнгэрийг тэтгэгч хааны зарлиг гарсны дараанаас 1779 онд зарлигаар жилд хоёр удаа зун, намарт тахьдаг болсон гэдэг. 2004 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн тахилгатай уулсын нэг болгож 5 жилд нэг удаа төрийн тахилга үйлдэх болсон.

ГЭРИЙН ДААЛГАВАР



Сурах бичиг 148 хуудас
асуултад хариулж
бичих